

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР
ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ ¹ 18 (ТОЙМ)**

Хуралдаан 2009 оны 8 дугаар сарын 27-ны өдрийн 14.30 цагт эхэлж, 16.50 цаг хүртэл Засгийн газрын Х1 байрын 301 тоот өрөөнд болж, нийт 2 цаг 20 минут үргэлжлэв.

1	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн гомдлыг шалгасан тухай танилцуулга	4 зүйлийн асуудлыг протоколд тусгаж Нийгмийн даатгалын ерөнхий газарт мэдэгдэх нь зүйтэй.
2	Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулсан дүнгийн тухай	Нөөцөд бүртгэгдсэн иргэдээс Лхагваагийн Мөнхбаатарыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан тушаалд томилуулахаар санал, дүгнэлт гарган нэр дэвшүүлж Монгол Улсын Ерөнхий сайд С.Баярт санал болгох тухай ТАЗ-ийн тогтоол гарав.
3	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилогдох ажилтныг нэр дэвшүүлэх тухай	Чулуунбатын Сайнбилэгийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд даргын албан тушаалд томилуулахаар санал, дүгнэлт гарган нэр дэвшүүлж томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол.
4	Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын нэгжийн дарга нарын албан тушаалуудад томилогдох ажилтнуудыг нэр дэвшүүлэх тухай	1/Аюушийн Ариунболдыг Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хууль, хяналт зохицуулалтын газрын даргын; 2/Бат-Очирын Оюунцэцэгийг Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Зах зээл, судалгааны газрын даргын; 3/Балжиннямын Пүрэвжавыг Засгийн газрын тохируулагч агентлаг Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Хамтын ажиллагааны газрын даргын албан тушаалд тус тус томилуулахаар санал дүгнэлт гарган, нэр дэвшүүлж томилох эрх бүхий албан тушаалтанд санал болгосон тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гарав
5	Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалуудад томилогдох ажилтныг нэр дэвшүүлэх тухай	1.Дашбалжирын Нэмэхбаярыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын даргын албан тушаалд томилуулахаар санал, дүгнэлт гарган нэр дэвшүүлж томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гарав.
6	Үндэсний статистикийн хорооны даргаар ажиллаж байсан П.Бямбацэрэн, Зэвсэгт хүчний жанжин штабын даргаар ажиллаж байсан Ц.Тогоо нарын төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх хүсэлтийн тухай	1.Төрийн албаны зөвлөлд гаргасан хүсэлт болон Төрийн албаны тухай хуулийн 17.11-д заасныг үндэслэн 2002-2009 онд Монгол Улсын Үндэсний статистикийн газрын болон Үндэсний статистикийн хорооны даргаар ажиллаж байсан Пандийн Бямбацэрэн, 2002-2009 онд Засгийн

		газрын агентлаг Зэвсэгт хүчний жанжин штабын даргаар ажиллаж байсан Цэвэгсүрэнгийн Тогоо нарыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэх тухай МУ-ын ТАЗ-ийн тогтоол гарав.
7	Яам, агентлагийн дарга нарын томилгооны дүнгийн талаарх танилцуулга, санал	Танилцуулав.
8	Төрийн жинхэнэ албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	Танилцуулга
9	Төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөхөх талаар авах арга хэмжээний тухай	“Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх, төрийн жинхэнэ албан тушаалд томилгоо хийх талаар өгөх зөвлөмж” гаргахаар тогтов.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ